



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 27 өдөр

Дугаар А/654

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 42 дугаар зүйлийн 42.2.1.в дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дэлгэрэх гол төслийн үргэлжлэл Арвайхээр сумын ногоон байгууламж нэмэгдүүлэх ажлын зураг төслийн үлдэгдэл 3,000,000 (гурван сая) төгрөг, Ахмадын өргөө-Хүүхдийн ордон чиглэлийн 703 метр урттай авто зам, Арвайхээр сумын 6 дугаар багийн 450 метр урттай авто зам, Уянга сумын Жаргалант багийн Таацын голын 45 метр урттай модон гүүрний зураг төсөл, зохиогчийн хяналтын үлдэгдэл 6,700,000 (зургаан сая долоон мянга) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2.Зураг төсөл боловсруулсан компанитай тооцоо хийж дээрх 9,700,000 (есөн сая долоон мянга) төгрөгийн зардлыг 2021 оны төсөвт батлагдсан орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зураг төсвийн зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101386